



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021

оны

06

сарын

04

өдөр

Дугаар

A/121

Мандалговь

“Экогое” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн A/45 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сан, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Инженерийн хийцтэй худаг” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Экогое” ХХК-тай 221,502,704 (хоёр зуун хорин нэгэн сая таван зуун хоёр мянга долоон зуун дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Худгийн стандартын дагуу Инженерийн хийцтэй худаг барих ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Экогое” ХХК-ний захирал (М.Анар)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

Л.ДОРЖБАТ

486210513